

**БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САНД  
ХӨРӨНГӨ ТӨВЛӨРҮҮЛЭХ ЖУРАМ**

НЭГ:Ерөнхий зүйл

Энэхүү журмын зорилго нь:

Мэдээлэл ,Шуудан,Харилцаа Холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд /цаашид БНҮҮСан гэх/ хөрөнгө төвлөрүүлэх,түүнтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино. Мэдээлэл,шуудан,харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх/болон Мэдээлэл,Шуудан, Харилцаа Холбоо,Технологийн Газар нь /цаашид ХХМТГ гэх/энэхүү журмыг мөрдөхдөө “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль” “Харилцаа холбооны тухай хууль” “Шуудангийн тухай хууль” “Харилцаа Холбооны Зохицуулах Хороо тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан “Тусгай зөвшөөрлийн гэрээ” болон тэдгээртэй холбогдон гарсан бусад журам,шийдвэр,баримт бичгийг удирдлага болгоно.

ХОЁР: Санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ

- 2.1 Мэдээлэл,шуудан,харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь “Засгийн газрын тусгай сангийн тухай”хуулийн 22.2-т заасны дагуу тухайн этгээдийн албан татвар ноогдох орлогын 2 хувьтай тэнцүү байна.
- 2.2 Шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь энэхүү журмын 2.1-д зааснаас гадна Шуудангийн хуулийн 9.1.2-т заасны дагуу төвлөрүүлэх хөрөнгөөс тус тус бүрдэнэ.

ГУРАВ:Харилцаа Холбоо,Мэдээллийн Технологийн Газрын эрх,үүрэг

3.1 Харилцаа Холбоо,Мэдээллийн Технологийн Газрын эрх

- 3.1.1 "БНҮҮСанд хөрөнгө төвлөрүүлэх тайлангийн маягт"-ыг боловсруулан,баталж, мөрдүүлэх:
- 3.1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс санд хөрөнгө төвлөрүүлэх,тайланг журмын 3.1.1-д заасан маягтын дагуу гаргуулан,татварын албанд тайлагнасан санхүүгийн тайлангийн хамт тайлант улирлын дараа улирлын эхний сарын 25-ны дотор авах,ирүүлэх шаардах:
- 3.1.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс маягтын дагуу ирүүлсэн тайланг санхүүгийн тайлан тэнцэлтэй нь тулган хянаж,тооцоо нийлж,төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг баталгаажуулах:
- 3.1.4 Тухайн улиралд санд төвлөрүүлэхээр баталгаажуулсан хөрөнгийг дараа улирлын дундах сарын 25-ны дотор Төв төрийн сангийн дансанд төвлөрүүлэн авах, төвлөрүүлэхийг шаардах:
- 3.1.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, төрийн сан, татварын алба, сангийн хяналтын зөвлөл, бусад эрх бүхий этгээдээс санд төвлөрүүлэх хөрөнгийн талаар гаргасан

гомдол хүсэлтийн дагуу шаардлагатай хяналт шалгалтыг явуулах, дүгнэлт гаргах, дүгнэлтийн дагуу үүрэг даалгавар өгөх:

- 3.1.6 Санд төвлөрүүлэх хөрөнгийг хугацаа хэтрүүлсэн, төвлөрүүлээгүй, санаатайгаар зайлсхийсэн, зориудаар хуурамчаар тайлагнасан этгээдийн тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах, үйлчилгээ эрхлэгчдээс хөрөнгө төвлөрүүлэхийг шаардах эрхтэй:
- 3.1.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт тусгай зөвшөөрөл нэмж олгох, сунгах, цуцлах тухай бүр энэхүү журмыг мөрдөж ажилласан эсэхийг ХХЗХороотой хамтран нягтлан шалгаж, шийдвэр гаргахдаа харгалзан үзэх
- 3.2 **Харилцаа холбоо, Мэдээллийн Технологийн Газрын үүрэг**
- 3.2.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ирүүлсэн санхүүгийн тайлан, түүнтэй холбогдох мэдээллийн нууцлалыг холбогдох хууль, журмын дагуу хадгалах:
- 3.2.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд санд төвлөрүүлэх хөрөнгийнхөө хэмжээг тогтоох, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгахад нь зөвлөгөө өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх:
- 3.2.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, төрийн сан, татварын алба, сангийн хяналтын зөвлөл, бусад эрх бүхий этгээдээс санд төвлөрүүлэх хөрөнгийн талаар гаргасан гомдол, санал, хүсэлтийг өөрт олгогдсон эрх, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд шуурхай хүлээн авч, хянан шийдвэрлэх, үр дүнг гомдол гаргагч этгээдэд болон нийтэд мэдээлэх

ДӨРӨВ. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

- 4.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх
- 4.1.1 Санд төвлөрүүлэх хөрөнгө, түүнтэй холбогдох асуудлаар гомдол саналаа шууд бие даан болон төлөөлөх эрх бүхий этгээдээр дамжуулан **ХХМТГазарт** гаргах, шийдвэрлүүлэх
- 4.1.2 **ХХМТГазарт** гаргаж өгсөн өөрийн үйл ажиллагаатай холбогдох мэдээллийн нууцлалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хадгалахыг **ХХМТГазраас** шаардах
- 4.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг
- 4.2.1 ХХМТГазраас баталсан “БНҮҮСанд хөрөнгө төвлөрүүлэх тайлангийн маягт”-ыг мөрдөх
- 4.2.2 Санд хөрөнгө төвлөрүүлэх тайлангаа журмын 3.1.1-д заасан маягтын дагуу гарган, татварын албанд тайлагнасан санхүүгийн тайлангийнхаа хамт тайлант улирлын дараа улирлын эхний сарын 25-ны дотор **ХХМТГазарт** гаргаж өгөх
- 4.2.3 **ХХМТГазраас** хянаж, тооцоо нийлж, баталгаажуулсан санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг шууд хүлээн зөвшөөрч, нягтлан бодох бүртгэлдээ тусгах
- 4.2.4 Тухайн улиралд санд төвлөрүүлэхээр ХХМТГазраас баталгаажуулсан хөрөнгийг дараа улирлын дундах сарын 25-ны дотор Төв төрийн сангийн дансанд төвлөрүүлэх

4.2.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, төрийн сан, татварын алба, сангийн хяналтын зөвлөл, бусад эрх бүхий этгээдээс санд төвлөрүүлэх хөрөнгийн талаар гаргасан гомдол хүсэлтийн дагуу ХХМТГазраас хийх хяналт шалгалтыг саадгүй хийлгэх, гаргасан дүгнэлтийн дагуу өгсөн үүрэг даалгаврыг үл маргах журмаар биелүүлэх

#### ТАВ. Хариуцлага

5.1 Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд ХХМТГазар нь холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авна.

Үүнд:

5.1.1 Зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх:

5.1.2 Зөрчлийг бүрэн арилгах хүртэл хугацаанд Монгол улсын Засгийн газраас батлагдсан төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд сангаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд оролцох эрхийг түдгэлзүүлэх:

5.1.3 Захиргааны хариуцлага хүлээлгэх, арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх:

5.1.4 Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах:

5.1.5 Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх:

5.1.6 Тусгай зөвшөөрлийг цуцлах зэрэг арга хэмжээг зохицуулах хороотой хамтран авч хэрэгжүүлэх

**ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР**